

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 28/14

Улаанбаатар хот

Онцгой нөхцөл бүхий Хөдөлмөрийн гэрээг цуцлах тухай

Компанийн тухай хуулийн 76.1.8, 76.1.18, Хөдөлмөрийн тухай хуулийн 79.1,79.3, Даатгалын тухай хуулийн 55.3, Компанийн дүрмийн 8.12.9, Онцгой нөхцөл бүхий Хөдөлмөрийн гэрээний 7.1.1, ТУЗ-ийн 2023 оны 06-р сарын 29-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Бодь даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Золбаярын Онцгой нөхцөл бүхий Хөдөлмөрийн гэрээг өөрийн хүсэлтийг нь үндэслэн 2023 оны 06 сарын 30-наар тасалбар болгон дуусгавар болгосугай.
2. Бодь даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирлын ажлыг хүлээн авах Комиссыг Аудитор Д.Төрмандах / ажлын хэсгийн ахлах /, Дотоод Аудитор Ш.Бэжид, ТУЗ-ийн Хуульч Г.Төгөлдөр, Давхар Даатгалын газрын захирал Б.Хүдэртулга, Үйл ажиллагааны газрын захирал М.Мөнхбаатар, Санхүү хөрөнгө оруулалтын захирал А.Энхжаргал, Хууль эрх зүй, нөхөн төлбөрийн газрын захирал Ж.Даваасүрэн, Хүний нөөцийн ахлах менежер Ц.Пүрэвжаргал, Техник хангамжийн инженер А.Батхуяг нарын бүрэлдэхүүнтэй байгуулсугай.
3. Бодь даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Золбаярын ажлыг холбогдох дүрэм журам, Онцгой нөхцөл бүхий Хөдөлмөрийн гэрээний дагуу хүлээлцэж авах, холбогдох хууль тогтоомж дүрэм журамд заасны дагуу цалин, тэтгэмжийг бодож олгох, авлагын тооцоо хийхийг Санхүү хөрөнгө оруулалтын захирал А.Энхжаргал даалгасугай.
4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах, хууль тогтоомжийн дагуу тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой СЗХ, Хөрөнгийн биржид бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Давхар Даатгалын газрын захирал Б.Хүдэртулгад үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ